

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
“Компанийн засаглалын кодекс”-ийн
хэрэгжилтийн тайлан 2025 он
(Санхүүгийн Зохицуулах Хороо хянан баталгаажуулсан)

Улаанбаатар хот
2025 оны 12-р сарын 30

Монложистикс Холдинг ХК-ийн

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний тайлангийн товч тойм

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж болон үнэлгээний аргачлал”-ын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж болон үнэлгээний аргачлал”-ын дагуу Монложистикс Холдинг ХК-ийн ТУЗ-өөс 2025 оны эхний хагас жилийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг хийж, Санхүүгийн зохицуулах хороо үнэлгээг хянан баталгаажуулсан.

Бид “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос өнгөрсөн жил өгсөн зөвлөмж, санамжийн дагуу тайлбар, нотлох баримтыг бүрдүүлэн, сайжруулахад анхаарч ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийн дагуу 36 асуулга бүхий үнэлгээний загвараар өөрийн үнэлгээг хийсэн бөгөөд доорх 3 аргачлалын дагуу үнэлж, Санхүүгийн зохицуулах хорооны хянан баталгаажилтын дүнтэй харьцуулсан байдлаар үнэлгээний нэгдсэн дүнг хүснэгтээр гаргалаа. Үүнд:

- Агуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2 оноо
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1 оноо
- Хэрэгжүүлээгүй бол 0 оноо

“Компанийн засаглалын кодекс”-ийн нэгдсэн үнэлгээгээр нийт авбал зохих онооны 90% болон түүнээс дээш авч байвал засаглал сайн, эрсдэлгүй гэсэн ангилалд хамрагддаг бөгөөд Монложистикс Холдинг ХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа нийт компаниудиа “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн 96,8%-ийн үнэлгээгээр, байр эзлүүлсэн зэрэглэлээр 2024 онд 3-р байрт, Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч ТОП 20 компанийн нэгээр шалгарч байсан.

2025 оны эхний хагас жилийн хянан баталгаажилт хийгдсэн үнэлгээгээр 95.8%-ийн үнэлгээгээр, байр эзлүүлсэн зэрэглэлээр мөн 3-р байрт шалгарсан байна. Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилал 2025 оны 9-р сард шинэчлэгдэж, Монложистикс Групп (MSE:MLG) нь I ангилал руу дэвшлээ. Монголын хөрөнгийн бирж дээрх хувьцаануудын арилжааны идэвх, зах зээлийн үнэлгээ, компанийнх нь засаглал, мэдээллийн ил тод байдал зэрэг олон шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, I ангилалд шилжүүлсэн юм.

Монложистикс Холдинг ХК-ийн
“Компанийн засаглалын кодекс”-ийн нэгдсэн үнэлгээ

2024 оны 8 сарын 30-ны өдрийн байдлаар

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Өөрийн үнэлгээний оноо	СЗХ-ны хяналтын оноо	СЗХ-ны хяналтын хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	11	91,6%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	8	80%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	8	100%
8	Компанийн соёл	6	5	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	10	100%
	Нэгдсэн дүн	72	71	69	95,8%

Тайлбар: Компанийн засаглалын өөрийн үнэлгээгээр **“Засаглал хэвийн буюу эрсдэлгүй”** түвшинд үнэлэгдлээ.

Монложистикс Холдинг ХК-ийн

Компанийн засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлан

2025 оны 08 сарын 30-ны өдрийн байдлаар

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	СЗХ-ны үнэлгээ	Хувь	Үүрэг даалгавар
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Хэрэгжилт: “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, гишүүдийн эрх үүрэг, Нарийн бичгийн даргын эрх үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан. Журам харах	2	100%	
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Хэрэгжилт: ТУЗ-ийн дэргэдэх “Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам”-аар ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг зохицуулсан. “Компанийн эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-аар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлж байна.	2	100%	
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Хэрэгжилт: ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг компанийн цахим хуудсанд (https://investor.mlholding.mn/company-zasaglal/) байршуулсан бөгөөд жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гишүүдийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодоор, ирцээр зэргээр нарийвчлан тайланд	2	100%	

		тусгасан. ХЭХ-д жилийн ажлын тайлангаа танилцуулсан Жилийн тайлан 48-51 хуудаст.			
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Хэрэгжилт: ТУЗ болон түүний дэргэдэх хороод нь бүтэц, бүрэлдэхүүн, хорооны эрх, үүрэг, үйл ажиллагааг зохицуулсан тус тусын журамтай. https://investor.mlholding.mn/tuziin-togtool-durem-juram/ хороодын журмууд. ТУЗ-ийн дэргэдэх “Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам”-д ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, мэргэшил, ажлын туршлага зэрэг тавигдах шаардлагыг тусгасан. Компанийн ТУЗ-д өнгөрсөн жилийн хувьд өөрчлөлт ороогүй.	2	100%	
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Хэрэгжилт: ТУЗ-ийн гишүүдийн сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулахаар жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан байгаа бөгөөд ТУЗ-ийн гишүүдэд зориулсан 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. ТУЗ-ийн НБД нь МХБ, бусад байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэг, арга хэмжээнүүдэд хамрагдаж, туршлага судлав.	1	50%	Хагас жилийн үнэлгээгээр 1 оноо авсан бөгөөд Сургалтын төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцэст СЗХ-д хүргүүлсэн.
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Хэрэгжилт: ТУЗ-ийн НБД нь ажлын гүйцэтгэлийн үр дүнгээ ТУЗ-д улирал бүр ажлын гүйцэтгэлийн тайлангаар дамжуулан тайлагнаж ажилладаг.	2	100%	
ДҮН (Авбал зохих оноо-12)			11	91,6%	
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хэрэгжилт: Компанийн ТУЗ нь нийт 9 гишүүнтэй ба 4 хараат бус, 5 ердийн гишүүнтэй. Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7.4-д “Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхыг хараат бус гишүүн байлгахыг зорино.” гэж тодорхойлсон.	2	100%	

8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжилт: ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь үйл ажиллагааны журам, аудитын бодлогын баримт бичигтэй. Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн ажилладаг. Хорооны хуралд гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд зөвхөн хүсэлтээр оролцож болох ба саналын эрхгүй байна гэж журамд тусгасан. Хорооны журам	2	100%	
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжилт: Нэр дэвшүүлэх, Цалин, урамшууллын хамтарсан хороотой Хорооны журам Компани нь цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороог хамтатган байгуулсан хэдий л Компанийн тухай хуулийн 81.5 болон 81.6-д заасанд нийцүүлэн үндсэн чиг үүргийг нь тус хорооны журамд нарийвчлан зааж өгсөн.	1	50%	Нэр дэвшүүлэх, Цалин, урамшууллын хамтарсан хороотой
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэрэгжилт: Нэр дэвшүүлэх, Цалин, урамшууллын хамтарсан хороотой	1	50%	Нэр дэвшүүлэх, Цалин, урамшууллын хамтарсан хороотой
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Хэрэгжилт: ТУЗ нь Стратеги, бизнес хөгжлийн хороотой бөгөөд хорооны үйл ажиллагааны журмаар тус хорооны чиг үүрэг, бүтэц, хорооны хурлыг зохион байгуулах, шийдвэр гаргалт зэрэг ажиллах журмыг тодорхойлсон.	2	100%	
ДҮН (Авбал зохих оноо-10)			8	80%	
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжилт: Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмын хэрэгжилтэд ТУЗ-с хяналт тавьж ажилладаг. Жилийн тайлан -гийн 52-р хуудаст ил тод байдал, тайлагналын мэдээллийг тусгаж, олон нийтэд мэдээлэл өгсөн. 2024 онд нийт 17 дүрэм журам, 10 тогтоол, 5 тайланг бид олон нийтэд мэдээлсэн байна.	2	100%	

13	3.2. ТУЗ нь энэхүү кодекс заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хэрэгжилт: Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмын дагуу олон нийтэд мэдээлэх тогтоол, тайлан, журам зэргийг МХБ -ийн цахим хуудсаар болон хөрөнгө оруулагчдад зориулсан дараах цахим хуудсанд тогтмол оруулж байна. Гадны хөрөнгө оруулагчдад зориулсан англиболон хятад хэл дээр тайлангаа гаргаж байгаа. https://investor.mlholding.mn/	2	100%	
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Хэрэгжилт: Компани үйл ажиллагааны Жилийн тайлан -даа үндсэн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээлэл, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу дэлгэрэнгүй тайлагнаж, хөндлөнгийн аудитын дүгнэлтийн хамт оруулдаг. Мөн тогтвортой хөгжлийн тайланг нийгэм, байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлууд, тэдгээрийн үр дүнгийн хамт, засаглалын тайланг КЗК-ийн шаардлагад нийцүүлэн дэлгэрэнгүй тайлагнаж, өөрийн цахим хуудас, МХБ-ийн цахим хуудас, олон нийтийн бусад цахим сүлжээгээр нээлттэй мэдээлж байна.	2	100%	
ДҮН (Авбал зохих оноо-6)			6	100%	
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжилт: ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны журамд хөндлөнгийн аудиторыг сонгох, хамтран ажиллах чиг үүргийг дэлгэрэнгүй тусгасан бөгөөд ТУЗ нь хорооны үйл ажиллагааны журмын хэрэгжилтэд хяналт тавьдаг. Дотоод аудиторын жилийн ажлын төлөвлөгөөг хороо батлаж, улирал тутам ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг авч танилцах, төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу ажлын уулзалт хийж ажлын явц буюу охин компаниудад хийгдсэн аудитын тайлантай танилцаж, чиг үүрэг өгч ажилладаг.	2	100%	
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэрэгжилт: Компанийн дүрмийн 10.13-т “Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд гаргасан дүгнэлтийнхээ талаар тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно” гэж заасан.	2	100%	

		Хөндлөнгийн аудит хийсэн Гранд Торнтон компанийн аудитын партнер Н. Эрдэнэцог, Д.Булган нар нь аудитын тайлан, дүгнэлтээ 2025/04/26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, хуралд оролцсон.			
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Хэрэгжилт: Компанийн цахим хуудсанд дотоод аудитын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг үйл ажиллагааны тайлан болон цахим хуудаст оруулсан. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд дотоод аудитын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг “Дотоод хяналтын тогтолцоо” нэртэй 5-р бүлэг болгон тусгайлан оруулсан. Жилийн тайлан -гийн 52-61 хуудас	2	100%	
ДҮН (Авбал зохих оноо-6)			6	100%	
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэрэгжилт: Эрсдэлийн удирдлагын журамтай. “Эрсдэлийн баг” (Хавсралт 11) томилогдон, бизнесийн эрсдэлийг тодорхойлж, түүнд чиглүүлэн авах арга хэмжээг төлөвлөн ажилладаг бөгөөд охин компаниуд бизнесийн эрсдэл, мөн үйл ажиллагааны эрсдэлээ тодорхойлон ажилладаг. Дотоод аудитор нь эрсдэлийн удирдлагын журмын хэрэгжилт, өндөр эрсдэлүүдийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж, ТУЗ-д тайлагнах замаар ТУЗ хяналтаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	2	100%	
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Хэрэгжилт: ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн удирдлагын хороотой, уг хороо нь 3 гишүүнтэй, олонхи нь хараат бус гишүүн юм. https://investor.mlholding.mn/company-zasaglal/ Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны журамтай. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлангийн Засаглал болон Дотоод хяналтын тогтолцоо бүлгүүдэд хорооны хурлын талаарх мэдээллийг оруулсан. 2024 онд Аудит, эрсдэлийн удирдлагын хороо нь 8 удаа хуралдаж, хорооны чиг үүрэгт хамаарах 15 асуудлыг	2	100%	

		хэлэлцэж, санал дүгнэлтээ ТУЗ-д танилцуулан ажилласан байна.			
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэрэгжилт: Компанийн “Эрсдэлийн баг” нь 2024 онд бизнесийн, тактикийн болон үйл ажиллагааны (ХАБЭА) түвшний эрсдэлүүдийг үнэлэн тогтоож, эрсдэлийн нөлөөллийг бууруулах, боломжийг ашиглах төлөвлөгөөг боловсруулсан. 2024 оны хамгийн өндөр түвшний эрсдэлүүд, түүнд чиглүүлэн авах арга хэмжээний талаар жилийн үйл ажиллагааны тайлангийн 60-р хуудаст тусгаж, олон нийтэд тайлагнасан.	2	100%	
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэрэгжилт: Компани комплайнсын удирдлагын журамтай бөгөөд нийцлийн үйл ажиллагааг хариуцаж, ТУЗ-д тайлагнаж ажиллах чиг үүргийг Нийцлийн ажилтан хариуцаж ажилладаг. 2024 онд нийцлийн үнэлгээ хийж, үр дүн, залруулах арга хэмжээний төлөвлөгөөг ТУЗ-д танилцуулсан бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитор нь охин компаниудын үл нийцлийг залруулах төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллах тогтолцоог хэрэгжүүлж байна. (Жилийн тайлангийн 60-р хуудас)	2	100%	
ДҮН (Авбал зохих оноо-8)			8	100%	
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Хэрэгжилт: 2024 оны 4 сарын 27-ны өдрийн ХЭ-ийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамж зэргийг ХЭХ-д танилцуулж, санал хураалт явуулан цалинг шинэчлэн тогтоосон. (Хавсралт 10)	2	100%	
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Хэрэгжилт: Компани Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг батлаж хэрэгжүүлдэг. харах 2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн цалингийн зардлын мэдээллийг тусгаж, олон нийтэл нээлттэй мэдээлсэн.	2	100%	

24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Хэрэгжилт: Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин болон урамшуулалт цалинг олгох шалгуур үзүүлэлтийн талаар мэдээллийг тусгасан. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тай байгуулсан үр дүнгийн гэрээний үндсэн дээр жилийн эцэст компанийн ашигт ажиллагаа, стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлээс хамааран урамшуулалт цалин тооцдог.	2	100%	
ДҮН (Авбал зохих оноо-6)			6	100%	
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Хэрэгжилт: Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлоготой.	2	100%	
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Хэрэгжилт: Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын хүрээнд богино, дунд, урт хугацааны стратеги зорилгыг батлан, голлон анхаарах асуудлуудаа тодорхойлсон бөгөөд энэ тухай мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайлангийн 58-р хуудаст тусгасан.	2	100%	
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Хэрэгжилт: 2024 онд бид оролцогч талуудтай харилцах, хөрөнгө оруулагчдад мэдээллийг шуурхай бөгөөд цэгцтэй хүргэх зорилгоор https://investor.mlholding.mn/ вэб хуудсыг шинээр нэвтрүүлж, тогтмол мэдээллээ оруулан хөтлөж байна. Мөн “Monlogistics Group” фэйсбүүкийн хуудсаар дамжуулан дээрх мэдээллийг хүргэж байна.	2	100%	
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Хэрэгжилт: Компанийн Хөдөлмөрийн Дотоод журам нь хөдөлмөрийн харилцааны олон талт асуудлуудыг зохицуулсан тусдаа журмуудаас бүрддэг бөгөөд ажилтны гомдол, саналыг хүлээн авах буюу шүгэл үлээх бодлого, ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх журам, нийгмийн асуудлыг шийдвэрлэх сайшаал	2	100%	

		шагнал, хөнгөлөлт хангамж, тэтгэмж тусламжийн багц журмууд, мэргэжил дээшлүүлэх асуудлаар сургалт хөгжлийн багц журмуудыг хэрэгжүүлж, ажлын төлөвлөгөө гарган ажилладаг.			
ДҮН (Авбал зохих оноо-8)			8	100%	
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжилт: Компанийн үнэт зүйлс, алсын харааг тодорхойлсон байдаг бөгөөд 2025 оны 5-р сард бид “ Ёс зүйн дүрэм ”-ээ шинэчлэн батлаж, бүх ажилтнууддаа сургалт хийлээ. Ёс зүйн дүрэм зөрчсөн аливаа үйлдлийг мэдээлэх системийг бүрдүүлсэн бөгөөд Шүгэл үлээх бодлогын хэрэгжилтийг ТУЗ-ийн НБД болон ТУЗ-ийн дотоод аудитор нар хариуцаж, ТУЗ-д шүгэл үлээсэн асуудлаар тайланг танилцуулж ажиллах тогтолцоотой.	2	100%	
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Хэрэгжилт: “Шүгэл үлээх” онлайн системийг ажиллуулж байна. https://investor.mlholding.mn/shugel-uleekh/ Шүгэл үлээх бодлого	2	100%	
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Хэрэгжилт: Ёс зүйн дүрэмд тусгагдсан.	2	100%	
ДҮН (Авбал зохих оноо-6)			6	100%	
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Хэрэгжилт: Хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудад зориулсан investor.mlholding.mn цахим хуудас, Компанийн албан ёсны www.mlholding.mn цахим хуудас, “Monlogistics Group” болон “Монложистикс Холдинг ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн групп” фэйсбүүк хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч зэрэг бүх оролцогч талуудад зориулсан санхүүгийн болон санхүүгийн бус мэдээ, мэдээллийг тогтмол хүргэж байна. Хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудад мэдээллийг илүү хүртээмжтэй хүргэх зорилгоор МХБ-	2	100%	

		ийн цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааны тайлангаа 2025.08.06-нд танилцуулсан . Мөн СММ компанийн зохион байгуулдаг Earning Call-д 2 удаа оролцож, олон нийтэд тайлангаа 2025.07.30-нд нээлттэй танилцуулсан. Сингапур улсад зохион байгуулагдсан хөрөнгө оруулалтын форумд оролцож, олон улсын хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэж, питч хийсэн. мэдээ харах			
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хэрэгжилт: Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр 2025-г баталсан бөгөөд, хэрэгжилтийг IR хариуцсан албан тушаалтай хариуцан ажиллаж байна. Оролцогч талуудтай харилцах, хөрөнгө оруулагчдад мэдээллийг шуурхай бөгөөд цэгцтэй хүргэх https://investor.mlholding.mn/tailan/ цахим хуудсанд тогтмол мэдээллээ оруулан хөтлөж байна.	2	100%	
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Хэрэгжилт: Компани хувьцаа эзэмшигчдийг эрхээ бүрэн эдлэх боломжоор бүрэн хангаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, хуралд оролцохгүйгээр урьдчилан саналаа өгөх, хуралдаа бүртгүүлээгүй ч хурлын үйл ажиллагаатай бүрэн танилцах боломжоор хангаж цахим хуудсаар шууд дамжуулалт хийж, хурлын материал, жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай урьдчилан танилцах, асуулт, санал хүсэлтээ хурлаас өмнө урьдчилан өгөх болон хурлын үеэр санал хүсэлт өгөх, асуулт асуух боломжоор бүрэн хангаж, хурлыг хуулийн дагуу хийж, хороогоор хянуулан ажиллаж байна.	2	100%	
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Хэрэгжилт: Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журамд тусгайлан тусгасан.	2	100%	
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэрэгжилт: Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай бөгөөд Аудит, эрсдэлийн удирдлагын хороо чиг үүргийн хүрээнд Дотоод аудиторoor дамжуулан хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилладаг. Жилийн үйл ажиллагааны тайлангийн 61-р хуудсанд бид их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар	2	100%	

	олон нийтэд мэдээлж, тогтоолуудыг тухай бүрт нь МХБ-ийн цахим хуудсанд байршуулан ажилласан. 2025 онд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай 2 тогтоолыг МХБ-ийн цахим хуудсанд байршуулсан.			
ДҮН (Авбал зохих оноо-10)		10	100%	
НЭГДСЭН ДҮН (Авбал зохих оноо-72)		69	95,8%	